



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар СХШ-2025/04

Сүхбаатар сум

Шаамар сумын Засаг даргын Тамгын
Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 17 дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Шаамар сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т. Мөнхзул 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Шаамар сумын Засаг даргын Тамгын газрын (цаашид сумын Шаамар сумын ЗДТГ гэх)-ын 2023, 2024 онуудын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Шаамар сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 9057293 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131255001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100131255408 дугаартай дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Шаамар сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Д.Энхзаяа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч А.Сэргэлэн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Шаамар сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 4, төрийн захиргааны албан хаагч 8, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 9, гэрээт ажилтан 7 нийт 28 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 92,6 хувь, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 90,6 хувь, Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 86.0 хувь хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2023 онд 5 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,480,244.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,244,971.5 мянган төгрөгийг 2024 онд 1,214,287.8 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 1,207,125.2 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	2023 онд			2024 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,480,244.9	1,244,971.5	235,273.4	1,214,287.8	1,207,125.6	7,162.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,289.8	790,251.3	85,038.5	1,168,343.2	1,162,661.7	5,681.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,636.8	789,751.3	82,885.5	1,134,858.6	1,130,150.6	4,708.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	433,110.5	410,862.2	22,248.3	683,794.7	682,759.5	1,035.2
210101	Үндсэн цалин	329,843.7	310,900.5	18,943.2	359,059.5	348,372.0	10,687.5
210102	Нэмэгдэл	103,266.8	95,280.3	7,986.5	195,304.8	259,804.6	-64,499.8
210104	Урамшуулал	0.0	4,681.3	-4,681.3	20,000.0	16,740.1	3,259.9
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	0.0	0.0	109,430.4	57,842.9	51,587.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,139.7	50,962.2	3,177.5	89,565.7	89,495.7	70.0
210201	Тэтгэврийн даатгал	36,814.7	34,595.1	2,219.6	59,612.4	59,542.4	70.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,331.1	4,216.4	114.7	6,778.1	6,778.1	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,465.3	3,411.3	54.0	5,422.2	5,422.2	0.0

210204	Ажилгүйдлийн даатгал	866.3	834.7	31.6	4,197.5	4,197.5	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,662.3	7,904.7	757.6	13,555.5	13,555.5	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,792.4	133,296.2	13,496.2	133,403.4	132,639.1	764.3
210301	Гэрэл, цахилгаан	17,789.6	16,067.1	1,722.5	20,836.4	18,071.1	2,765.3
210302	Түлш, халаалт	113,614.6	111,573.9	2,040.7	107,457.0	109,515.0	-2,058.0
210303	Цэвэр, бохир ус	15,388.2	5,655.3	9,732.9	5,110.0	5,052.9	57.1
2104	Хангамж, бараа материалын зардал	63,148.7	55,108.6	8,040.1	52,960.0	52,960.0	0.0
210401	Бичиг хэрэг	6,479.0	6,558.4	-79.4	10,626.9	10,626.9	0.0
210402	Тээвэр, шатахуун	32,100.7	28,323.1	3,777.6	28,064.1	28,064.1	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,510.5	3,197.1	1,313.4	2,734.5	2,734.5	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,514.8	5,425.1	3,089.8	4,800.0	4,800.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,543.7	11,605.0	-61.3	6,734.5	6,734.5	0.0
2105	Нормативт зардал	494.0	494.0	0.0	0.0	0.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	494.0	494.0	0.0	0.0	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,111.2	11,810.0	2,301.2	15,892.6	15,892.6	0.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,288.6	7,988.3	2,300.3	2,734.5	3,012.3	-277.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	622.6	622.6	0.0	0.0	0.0	0.0
210604	Урсгал засвар	3,200.0	3,199.1	0.9	13,158.1	12,880.3	277.8
2107	Томилолт, зочны зардал	3,947.9	3,650.0	297.9	2,000.0	1,992.0	8.0
210702	Дотоод албан томилолт	3,947.9	3,650.0	297.9	2,000.0	1,992.0	8.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,634.9	50,918.3	18,716.6	101,754.2	98,934.3	2,819.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,751.2	48,733.4	17,017.8	94,345.7	92,472.1	1,873.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	213.1	0.0	213.1	1,818.6	1,500.0	318.6
210803	Даатгалын үйлчилгээ	0.0	0.0	0.0	942.3	318.5	623.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,148.0	352.9	795.1	790.4	789.3	1.1
210807	Газрын төлбөр	451.9	136.9	315.0	3,681.6	3,678.8	2.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	0.0	0.0	175.6	175.6	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,257.5	72,649.8	14,607.7	55,488.0	55,477.4	10.6

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,200.0	72,084.3	14,115.7	54,394.2	54,387.4	6.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,057.5	565.5	492.0	1,093.8	1,090.0	3.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,653.0	500.0	2,153.0	33,484.6	32,511.1	973.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,653.0	500.0	2,153.0	33,484.6	32,511.1	973.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	0.0	0.0	14,960.6	13,987.1	973.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	0.0	18,524.0	18,524.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,653.0	500.0	2,153.0	0.0	0.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	604,955.1	454,720.2	150,234.9	45,944.6	44,463.9	1,480.7
223001	Бусад хөрөнгө	604,955.1	454,720.2	150,234.9	45,944.6	44,463.9	1,480.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,480,244.9	1,244,971.5	235,273.4	1,214,287.8	1,207,125.6	7,162.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,218,204.9	1,235,218.5	-17,013.6	1,204,627.8	1,196,204.2	8,423.6
320001	Орон нутгийн төсвөөс	1,218,204.9	1,235,218.5	-17,013.6	1,204,627.8	1,196,204.2	8,423.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	262,040.0	9,753.0	252,287.0	9,660.0	10,921.3	-1,261.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,560.0	9,753.0	-8,193.0	0	0	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28	0	27	27	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0	10	10	0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	0	5	5	0

2023 онд төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,244,971.5 мянган төгрөг буюу 84.1 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 243,466.4 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардал 85,038.5 мянган төгрөг, хөрөнгийн зардал 150,234.9 мянган төгрөгийн гүйцэтгэл дутуу болон өөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 8,193.0 мянган төгрөгөөр давсантай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 22,248.4 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 3,177.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,496.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 8,040.1 мянган төгрөгөөр, тавилга эд хогшлын зардлыг 2,301.2 мянган төгрөгөөр,

томилолтын зардлыг 297.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 18,716.6 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 14,607.7 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 2,153.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 150,234.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь байгууллагын үйл ажиллагааны орлогыг 1,560.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 9,753.0 мянган төгрөгөөр орлогыг төвлөрүүлж 8,193.0 мянган төгрөгөөр орлого давж, орон нутгийн төсвийн санхүүжилт 1,218,204.9 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжих 260,480.0 мянган төгрөгөөр батлагдсанаас 1,235,218.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 243,466.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас гүйцэтгэлээр зардал гаргах боломжгүй болсон байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2024 онд төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,207,125.6 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 8,423.6 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардал 5,681.5 мянган төгрөг, хөрөнгийн зардал 1,480.7 мянган төгрөгийн гүйцэтгэл дутуу болон өөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 1,261.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 1,035.2 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 70.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 764.3 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 8.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,819.9 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 10.6 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 973.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,480.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь байгууллагын үйл ажиллагааны орлогыг 9,660.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,921.3 мянган төгрөгөөр орлогыг төвлөрүүлж 1,261.3 мянган төгрөгөөр орлого давуулан биелүүлсэн мөн орон нутгийн төсвийн санхүүжилт 1,204,627.8 мянган төгрөгөөр батлагдсанаас 1,196,204.2 мянган төгрөгийн санхүүжилт авч 8,423.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас үүдэж батлагдсан зардлын гүйцэтгэлийг гараагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: 2023 онд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөс 15,163.4 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-аас 221,500.0 мянган төгрөгийн ОНХО-оос 30,000.0 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,150.5 мянган төгрөг зэрэг нийт 284,692.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 261,122.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2024 онд Аймгийн статистикийн хэлтэсээс мал тооллогын зардалд 1,419.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,328.2 мянган төгрөг, олон улсын чанартай замын барьцааны орлого зэрэг нийт 27,431.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 3,936.2 мянган төгрөгийг зарцуулж 23,495.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Сумын ЗДТГ-ын Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлын тушаал шийдвэр, цагийн тооцоо, цалингийн нэгдсэн систем, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад 2023 онд цалингийн зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөж урамшуулал, гэрээт ажилтны цалингийн зардлыг зардлын эдийн засгийн ангиллаар батлаагүй, үндсэн цалин нэмэгдэл цалингийн зардлаар баталснаар төсвийн хуваарь төлөвлөгдөөгүй 4,681.3 мянган төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр тайлагнагдсан.

Мөн ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /жолооч, үйлчлэгч, хэвлэл мэдээллийн ажилтан, жижүүр, / гэсэн албан тушаалын ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхээр баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд албан тушаалын ангиллыг ТҮ албан хаагчаар баталж тус ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулж орон нутгийн нэмэгдэл болон төрийн алба хаасан нэмэгдлийг олгосон байна.

Албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулалгүйгээр нэгэн адил хувь хэмжээгээр олгосон зөрчил дутагдал хяналт шалгалтын явцад тогтоогдсон байна.

2.4 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн боловч үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтлөхгүй байгаа нь санхүүгийн тайлан, мэдээлэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Иймд дээрх бүртгэлийн алдааг залруулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.9. Дотоод хяналтын үр нөлөө

Шаамар сумын санхүүгийн албаны 2023,2024 онуудад хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төрийн сантай холбоотой ажил гүйлгээний чиглэлээр зөвлөн туслах хяналт шалгалтыг 3, 10 дугаар саруудад гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжүүлсэн боловч дотоод хяналтын үр дүн сул байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Шаамар сумын ЗДТГ-ын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, цалин хөлсний тооцоолол, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Төсвийн зарлагыг ангилал хооронд гүйлгэн бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас бичиг хэргийн зүйл болон барилгын засварын материалд 9,306.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зардлыг гаргахдаа төсвийн зардлын ангиллын дагуу холбогдох данснаас гаргаж байх албан шаардлагыг хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Үйл ажиллагаа зохион байгуулах зардлын төсөв тооцоо, тушаал, хийгдсэн ажлын тайлангууд, гэрээ дүгнэсэн акт үйлдэх зэрэг 7,437.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалтад “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 3. 2023, 2024 онд Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвийн 68 хувийг 79 иргэнд 31,899.7 мянган төгрөгийг дэмжлэг тусламжинд хавтгайруулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, нөөц хөрөнгийн үлдэгдлийг 30 хувиас доошгүй хувийг бэлэн байршуулж байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Сумын 100 жилийн хандиваар өгсөн 16,958 мянган төгрөг бүхий 3 гэр, 2 компьютер болон бусад хөрөнгийг холбогдох дансанд бүртгээгүй зөрчил илэрсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх, 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх "Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын 100 жилийн хандиваар өгсөн 16,958 мянган төгрөг бүхий 3 гэр, 2 компьютер болон бусад хөрөнгийг холбогдох дансанд бүртгэх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцох хугацааг дутуу оруулж элэгдлийг буруу тооцоолсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа"-тай нийцэхгүй байна заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцох хугацааг бодлогын бичиг баримтад заасны дагуу дахин тооцоолж бүртгэл тайланд залруулж тусгах зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 6. Сумын ОНХС-ын хөрөнгөөр 2022, 2023 онд 396,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 88 ширхэг хүлэмжийг худалдан авч бараа материалд бүртгэн иргэдэд 5 жилд хуваан төлөх түрээсийн гэрээгээр олгосон байна. 2024 оны эцсээр онд түрээсийн 134,000.0 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэх атал 15,200.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 118,800.0 мянган төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Хүлэмжийн түрээсийн орлогыг хугацаанд нь бүрэн төлүүлж, зохих дансанд төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Шаамар сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Шаамар сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **184,402** мянган төгрөгийн **6** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **128,106,8** мянган төгрөгийн 2 албан шаардлага, давтан гаргахгүй 56,295.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН.


САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН.

ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Д.ЭНХЗАЯА

НЯГТЛАН БОДОГЧ А.СЭРГЭЛЭН